

ТӨМӨР БЕТОН ГҮҮР БАРИХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020... оны 05. дугаар
сарын 30-ний өдөр

№ ТХН-АЧГ/2020/001

Улаанбаатар хот

Энэхүү төмөр бетон гүүр барих ажил гүйцэтгэх гэрээг /Цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас: Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ыг төлөөлж Замын дарга Д.Жигжиднямаа (цаашид "Захиалагч" гэх),

Нэгт талаас: Улсын бүртгэлийн 9019011021, Регистрийн 2677393 дугаартай "Эйч Кэ Би интернэшнл холдинг" ХХК түүний ерөнхий захирал албан тушаалтай Жан Ван Жуныг төлөөлж 2020 оны 01-р сарын 15-ны өдрийн Итгэмжлэл №03-г үндэслэж "Эйч Кэ Би интернэшнл холдинг" ХХК түүний орлогч захирал албан тушаалтай Хибагат овогтой Мамбет /Б380110516/; (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар хүсэл, зориг, ашиг сонирхлоо бүрэн илэрхийлж Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйл заалтыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зоригоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг 2 тал харилцан хүлээн зөвшөөрөв.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго Дэд ажлын хэсгийн 2020 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын төмөр бетон гүүрүүдийн барилга, угсралтын ПК195+560 дахь 94,86м урттай, ПК196+920 дэх 94,86 м урттай, нийт 189,72 м урттай 2ш төмөр бетон гүүрийг барих ажлыг батлагдсан зургийн дагуу гэрээт ажлын дунд багтаан ажлыг гүйцэтгэх, энэхүү гэрээгээр харилцан тохиролцсон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахтай холбогдсон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн хүлээх үүрэг, эдлэх эрх болон хариуцлагыг тогтооход оршино.

1.2 Гэрээт ажил: Гэрээний хугацаанд энэхүү гэрээний 1.1-д заасан газарт хавсралт 1-д заасан ажлыг иж бүрэн хийж гүйцэтгэнэ.

1.3 Гэрээний нийт үнийн дүн: **11,814,662,205** /Арван нэгэн тэрбум найман зуун арван дөрвөн сая зургаан зуун жаран хоер мянга хоер зуун тав/ төгрөг байна. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөх буй татвар, хураамжуудыг ГЕН-ийн 49 дэхь хэсэгт заасны дагуу Гүйцэтгэгч нь хуульд заасан хэмжээгээр өөрөө хариуцсан барагдуулна.

1.4 Гэрээний үнийн задаргааг Хавсралт №4-д заасан болно. Энэ үнэнд тоног төхөөрөмж, холбох хэрэгсэл, тэдгээрийг суурилуулах болон материалын, ажлын хөлс, тээврийн зардал багтсан бөгөөд НӨАТ багтсан болно.

1.5 Дор дурьдсан гэрээ, баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд эдгээрийн хамт энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр байна. Үүнд:

- 1.5.1 Гэрээ
- 1.5.2 Гэрээний ерөнхий нөхцөлүүд
- 1.5.3 Гэрээний тусгай нөхцөлүүд
- 1.5.4 Хавсралт 1 Ажлын зураг (Ажлын даалгавар)
- 1.5.5 Хавсралт 2 Техникийн шаардлага /техникийн тодорхойлолт/
- 1.5.6 Хавсралт 3 Ажлын төсөв /зардлын задаргаа/
- 1.5.7 Хавсралт 4 Гүйцэтгэл тооцох хуваарь
- 1.5.8 Хавсралт 5 Ye шатны ажлын хуваарь
- 1.5.9 Хавсралт 6 Ажлын график төлөвлөгөө
- 1.5.10 Хавсралт 7 Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн жагсаалт, ажиллах хүчиний мэдээлэл,
- 1.5.11 Хавсралт 8 Ye шатны ажлын тайлан гаргах хуваарь
- 1.5.12 Хавсралт 9 Гэрээ дуусгавар болсны дараа хүлээлгэн өгөх бичиг баримтын жагсаалт
- 1.5.14 Хавсралт 10 Гэрээг гүйцэтгэх бараа, материал, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлын шаардлага,

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул оөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно. Page 2

С. Сүрье

1.5.15 Холбогдох бусад бичиг баримтууд /Гүйцэтгэгч компанийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, итгэмжлэл, гэрчилгээ, захидал эсвэл эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэх г.м /нотариатаар баталгаажуулсан байна/

ХОЁР. НЭР ТОМЬЁО

Энэхүү Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1 "Гэрээ" гэж Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан энэхүү ажил гүйцэтгэх Гэрээг,

2.2 "Захиалагч" гэж "УБТЗ" ХНН

2.4 "Гүйцэтгэгч" гэж "Эйч Кэ Би интернэшнл" ХХК-ийг;

2.5 "Гэрээний үнэ" гэж Үйлчилгээг гүйцэтгэхэд зориулан Гүйцэтгэгч энэхүү Гэрээний 1.3-д заасны дагуу баталсан төсвийн үнийн дүнг;

2.6 "Гүйцэтгэх ажил" гэж Гэрээний дагуу Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх энэхүү Гэрээний Хавсралт 1-д тодорхойлсон ажлыг;

2.7 "Ажил эхлэх өдөр" гэж Гүйцэтгэгчийн ажил эхлүүлэх өдрийг тус тус хэлнэ. Энэ өдрийг ГТН-ийн 1.3 дүгээр зүйлд заах бөгөөд ажлын талбайг эзэмших өдөртэй давхцаагүй байж болно.

2.8 "ГЕН" гэх товчилсон үгийг Гэрээний ерөнхий нөхцөл гэж ойлгоно,

2.9 "ГТН" гэх товчилсон үгийг Гэрээний тусгай нөхцөл гэж ойлгоно,

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Захиалагч нь Гүйцэтгэгчийг гэрээний хавсралт 1-д заасан ажлыг үр дүнтэй, чанарын шаардлагын дагуу, хугацаандaa гүйцэтгэхэд хяналт тавих үүрэг хүлээнэ.

3.2 Захиалагч нь Гүйцэтгэгчийн хариуцсан инженерээс ирүүлсэн гүйцэтгэлийн үнэн зөв, алдаагүй байдалд хяналт тавьж баталгаажуулна.

3.3 Ажлын хэрэгжилт, ажлын явц, тайлан мэдээтэй чөлөөтэй танилцах, газар дээр нь үнэлгээ шалгалт хийх, шаардлага тавих эрхтэй.

3.4 Захиалагчийн инженерүүд нь зөвхөн гүйцэтгэсэн ажлыг хянаж, харин санхүүжилтийг "МТЗ" ТӨХХ хариуцна.

3.5 Гүйцэтгэгч нь санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, төслийн хэрэгжилт, ажлын гүйцэтгэлийн явцад зөрчил гаргасан тохиолдолд гүйцэтгэлийг баталгаажулахгүй, улмаар гэрээг цуцлах эрхтэй.

3.6 Гэрээний үнийн дунд гэрээний хавсралт 2 заасан техникийн шаардлага, ажлын даалгаварт заасан бүх ажлыг бүрэн гүйцэтгэж хийж гүйцэтгэх бөгөөд илүү гарсан аливаа зардалд Захиалагч хариуцлага хүлээхгүй болно.

3.7 Ажлын явцад Захиалагчийн зүгээс ажлын зураг, төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд үүнтэй холбоотой ямар нэг нэмэгдэл зардлыг Гүйцэтгэгчид төлөхгүй болно.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

4.1 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох хавсралт 1-д заасан ажлыг үр дүнтэй, батлагдсан зураг төслийн дагуу техникийн болон чанар, стандартын шаардлага ханган гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

4.2 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт 1-д тодорхойлсон зураг төсөлд заасан ажлыг хийж гүйцэтгэх үүрэгтэй.

4.3 Гүйцэтгэгч нь ГТН-ийн 1.1 дүгээр зүйлд Захиалагчаас шаардаж буй хавсралт 1-д заасан ажил үүргийг хавсралт 2-т заасан техникийн шаардлагын дагуу гэрээнд заасан хугацааны дотор хийж гүйцэтгэх мэргэжлийн дадлага туршлагатай инженер, техникийн болон бусад ажилтнууд болон тоног төхөөрөмж, техникийн эх үүсвэртэй байна. Гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу ажлыг хийж гүйцэтгэхийг энэхүү гэрээгээр хүлээн зөвшөөрсөн байна.

4.4 Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан нөхцөл, болзодуулсан хувьтэй хавсралт 1-д заасан ажлыг зохих ёсоор гүйцэтгэж, зөрчил доголдол гаргасан үед түүнийг яаралтай засах, арилгах үүргийг хүлээнэ.

4.5 Ажлын явцтай холбоотой мэдээ тайланг Захиалагчид гэрээний хавсралт 8-д заасан хугацааны дагуу тухай бүр хүргүүлэх үүрэгтэй.

4.6 Санхүүжилт авахтай холбогдуулан хүргүүлсэн аливаа мэдээлэл, тайлан, нэхэмжлэхийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.

4.7 Гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээх үүргийг ГТН-ийн 6.1 дүгээр зүйлд нарийвчлан заасан болно.

4.8 Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан нөхцөлийн дагуу дурдагдсан ажлыг гүйцэтгэх явц болон чанаарын баталгаат хугацаанд гарсан эвдрэл гэмтлийг өөрийн зардлаар засах /солих/ үүрэг хүлээнэ.

4.9 ГТН-д өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь гэрээ байгуулахаас өмнө гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бүхий л шаардлагатай баримт бичиг, зөвшөөрөл, гэрчилгээг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан байх үүрэгтэй.

4.10 Дараах тохиолдолд Гүйцэтгэгч Захиалагчид санал гаргаж болно. Үүнд:
Гүйцэтгэх ажил үүргийг гэрээнд заасан хугацаанаас өмнө дуусгахтай холбоотой,
Гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг багасгахтай холбоотой,
Гүйцэтгэх ажил үйлчилгээний үр дүнг сайжруулах тухай, ашигтай санал зэрэг болно.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг буруутай тал нь хариуцна.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1 Энэхүү Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.2 Хэрэв тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд талууд уг маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1 Давагдашгүй хүчин зүйлийн талаар ГЕН-ийн 28 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

НАЙМ. БУСАД

8.1 Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Гэрээний хавсралт, нэмэлт Гэрээнүүд нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

8.2 Талууд ГЕН-ийн 4 дэх хэсэгт заасны дагуу Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд эрх бүхий албан тушаалтанууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр гэж тооцогдох ба энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна.

8.3 Гэрээнд заасан үүрэг биелэгдсэнээр ГЕН-ийн 52, 53 дахь хэсэгт заасны дагуу гэрээ дуусгавар болно.

8.4 Гэрээг 2 эх хувь үйлдэх ба хууль зүйн хувьд адил хүчин төгөлдөр байна.

8.5 Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, албан бичгийг дараах хаягаар хүргүүлнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухай бусад Талууддаа мэдэгдэх нь Талуудын үүрэг ба ийнхүү мэдээлээгүйгээс үүсэх хариуцлагыг тэдгээрийн хүргүүлсэн Тал хариуцахгүй болно.

8.6 Талууд гэрээний бүх заалттай бүрэн танилцаж маргаангүй болохыг нотолж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН
БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“УБТЗ” ХҮНН-ИЙН дарга

Д.ЖИГЖИДНЯАА/

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Эйч Кэй БИ Интернэшил холдинг” ХХК-
ны орлогыг захирагч

